

зөвлөлөөр батлуулан, бүх гишүүдэд мөрдүүлж ажиллах үндсэн үүрэгтэй.

Техникийн дэд зөвлөл нь 6 хүний бүрэлдхүүнтэй бөгөөд ахлагч нь С.Гантулга

Нийгмийн дэд зөвлөл:

Байдрагийн хөгжил ТББ-ын гишүүдэд тулгарч буй нийгмийн асуудлуудыг ТББ-ын шийдвэр гаргах түвшинд хүргэх, бизнес санаачлагыг нь дэмжин, ажил хэрэг болгоход үйл ажиллагаагаа чиглүүлэх. Нийгмийн дэд зөвлөл нь 11 хүний бүрэлдхүүнтэйгээр байгуулагдаад байна.

Гишүүнчлэл:

1. Тус ТББ-ын гишүүнээр 18 нас хүрсэн Жаргалант сумын байнгын оршин суугч, хувиараа ашигт малтмал олборлодог хүн бүр, сайн дурын үндсэн дээр хамтран нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон нөхөрлөл, түүний гишүүд элсэх боломжтой.
2. Байдрагийн Хөгжил ТББ-ын гишүүн нь дотоод дүрэм болон ХАМО-гч иргэдийн Баруун, Зүүн салаанд дагаж мөрдөх журмыг хүлээн зөвшөөрсөн байна.



Хамтран ажилладаг байгууллага:

- Тогтвортой Бичил Уурхай Төсөл
- Жаргалант сумын Засаг даргын тамгын газар
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- Сумын Хүний их эмчийн салбар
- Сумын Байгаль орчны хэсэг
- Сумын цагдаагийн тасаг

Манай хаяг:

Байдрагийн Хөгжил, ТББ
Баянхонгор аймаг, Жаргалант сум
Харилцах утас: 0144-226500, 88447032

Баянхонгор аймаг, Жаргалант сум

"БАЙДРАГИЙН ХӨГЖИЛ" Төрийн Бус Байгууллага



ТАНИЛЦУУЛГА



Тогтвортой
бичил уурхай
төсөл

“БАЙДРАГИЙН ХӨГЖИЛ” Төрийн бус байгууллага

Бидний түүх:

Байдрагийн хөгжил ТББ нь 2008 оны 01 сарын 07-ны өдөр Жаргалант сумын хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн эрх ашгийг хамгаалан, тэднийг орон нутгийн болон үндэсний түвшинд төлөөлж, бизнесийг нь дэмжсэн үйл ажиллагаа явуулан, байгаль орчныг хамгаалахад хувь нэмрээ оруулах зорилгоор анх байгуулагдсан билээ. Өнгөрсөн нэг жил гаруй хугацаанд бид Тогтвортой Бичил Уурхай Төслийн /ТоБУТ/ дэмжлэгтэйгээр сумынхаа хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн дунд олон төрлийн сургалт, сурталчилгаа, техникийн болон бусад төрлийн олон талт арга хэмжээг зохион байгуулсан. ТоБУТ-ийн дэмжлэгтэйгээр сургалт, мэдээллийн үйл ажиллагаа явуулах иж бүрэн “гэр” төвтэй болсон байгаа. Мөн олборлолт болон нөхөн сэргээлт хийх зорилгоор жижиг оврын тракторын хөрөнгө оруулалтын дэмжлэгийг хүртэл аваад байна.

Өнөөдрийн байдлаар манай ТББ нь Монгол Улсын Засгийн газрын 72-р тогтоолоор батлагдсан “Хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагааг зохицуулах” түр журмын хүрээнд нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон 37 нөхөрлөлийн 340 гаруй гишүүд, дэмжигчтэй болоод байгаа бөгөөд Тэргүүнээр Ж. Батзоригт, олон нийттэй харилцах ажилтнаар Э. Даш-Өлзий нар ажиллаж байна.



Бидний зорилго:

Хувиараа ашигт малтмал олборлогч гишүүдийнхээ эрх ашгийг орон нутгийн болон үндэсний түвшинд төлөөлж тэдний бизнесийг дэмжих үйл ажиллагаа явуулан, байгаль орчныг хамгаалахад хувь нэмэр оруулдаг Бичил уурхайн загвар бүхий гишүүддээ үйлчилдэг Төрийн Бус Байгууллага болох.

Үйл ажиллагааны чиглэл:

- Орон нутаг, улс, олон улсын түвшинд гишүүдээ төлөөлөн ажиллаж, тэдний нэгдмэл эрх ашгийг тууштай хамгаалах.
- Хувиараа ашигт малтмал олборлогч гишүүдийнхээ ашигт малтмал олборлох эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.
- Гишүүдийнхээ бизнесийг дэмжих зорилгоор төрөл бүрийн сургалт зөвлөлгөө өгөх ажлыг зохион байгуулах.
- Гишүүддээ зориулан шинжлэх ухаан, технологийн шинэ дэвшилтэт тоног төхөөрөмж, зах зээлийн талаархи мэдээлэл судалгааг явуулж шинэ мэдээллээр хангах.
- Гишүүдийнхээ дунд эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлийн төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.



Бүтэц зохион байгуулалт:

Манай ТББ-ын эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн Хурал бөгөөд тухайн хурлаас томилогдсон Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Техник, нийгмийн дэд зөвлөлүүдийн үйл ажиллагаагаар дамжуулан бид гишүүддээ хүрч ажилладаг.

Удирдах зөвлөл:

ТББ-ын дүрэмд зааснаар Удирдах зөвлөл нь Бүх Гишүүдийн Хурлаас баталсан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, гишүүддээ сурталчилан таниулах, Бүх гишүүдийн хурлаас баталсан ТББ-ын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг бусад дэд зөвлөлүүдийн хамтаар хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй. Байдрагийн Хөгжил ТББ нь Удирдах зөвлөлийн 11 гишүүнтэй.

Хяналтын зөвлөл:

Хяналтын зөвлөл нь Бүх Гишүүдийн Хурлаас баталсан бодлого, шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, санхүүгийн зарцуулалтын үйл ажиллагаанд сар бүр хяналт тавих үндсэн үүрэгтэй бөгөөд тус ТББ-ын хөрөнгө, санхүүгийн байдалд шалгалт хийж дүгнэлт гарган жил бүрийн эцэст бүх гишүүдийн хуралд тайлагнах үүрэгтэй.

Байдрагийн Хөгжил ТББ-ын Хяналтын зөвлөл 3 гишүүнтэй бөгөөд дарга нь З. Балдандорж

Техникийн дэд зөвлөл

Хувиараа ашигт малтмал олборлогч гишүүдийнхээ олборлолт болон ашиглалтын техник, технологийг сайжруулахад холбогдох талуудтай хамтран ажиллаж, дундын эзэмшлийн трактор аишглалтын төлөвлөгөөг боловсруулж, нөхөрлөлүүдийн газар ашиглах, нөхөн сэргээлт хийх хуваарийг улирлаар нь гарган Удирдах